

**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ОРОН НУТАГТ ХАМААРАХ ЗААЛТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРВАЙХЭЭР СУМЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 11 дүгээр сарын 25

Арвайхээр сум

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Суурь түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн түвшин		Биелэлтийн хувь
	2	3			Хүрсэн түвшин	6	
1			3	4	5		
Зорилго 2. Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ							
2.1.2. Төрийн албаны сул орон тооны талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх	Ажлын байрны тоогоор	ТЗ-5 ТҮ-6	Тухай бүр				100
2.1.5. Төрийн хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлах	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	1	3				100

Ажлын байрны сул орон тооны зарыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу төрийн албаны тусгай шалгалт өгч, хамгийн өндөр авсан иргэдийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлсэн Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолыг үндэслэн тайлан хугацаанд хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн, Рашаант 8 дугаар багийн зохион байгуулагчийг томилсон.

Ёс зүйн дэд хороо 2025 хийх ажлын төлөвлөгөөг 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран байгууллагын нийт алба хаагчдад сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Сургалт хэлэлцүүлгийн үеэр алба хаагчид “Уусан бол бүү жолоод” аянд нэгдэж, 50 албан хаагч гарын үсэг зурж баталгаажуулсан. Албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл зүй, сэтгэл ханамжийн талаар 15 асуулга бүхий судалгаа авч албан хаагчдын 67 хувь хамрагдсан байна. Судалгааны нэгдсэн дүнд үндэслэн feedback ярилцлага хийж ярилцлагын дүнг нэгтгэн удирдлагад танилцуулсан. “Хорт зуршлыг хогийн саванд хийцгээе” уриалга гарган 3 албан хаагч угаат тамхинаас татгалзан, хамт олноо манлайлж байна. Төрийн захиргааны, төрийн үйлчилгээний, улс төрийн нийт 74 албан хаагчийн харилцаа, хандлага ёс зүйг хамт олноор үнэлүүлж, үнэлгээний дунджийг гарган, үнэлгээ өгч, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд оруулан үнэлсэн.

2.2.1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, ил тод мэдээлэх	ХАСУМ-ийн тоогоор	9	Тухай бүр	Арвайхээр хотын захирагчийн албаны ерөнхий менежер, Согоот 1 дүгээр баг, Хүйс толгой 11 дүгээр баг, Бурхи 9 дүгээр баг, Ноён 10 дугаар багийн Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэхээр нэр дэвшсэн иргэдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг үндэслэн томилсон. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 4 дүгнэлтийг shilen.gov.mn сайтад нээлттэй байршуулсан.	100
2.5.2. Олон нийтэд нээлттэй, ил тод байхаар заасан мэдээллийг цахимд нээлттэй байршуулах	Shilen.gov.mn үнэлгээгээр	80,0	85,0	Олон нийтэд нээлттэй, ил тод байхаар заасан мэдээллийг Shilen.gov.mn сайтад улирал бүр тайлагнаж, 2025 оны нэгдүгээр улиралд 70,4 хувь, хоёрдугаар улиралд 81.2 хувь, гуравдугаар улиралд 91,5 хувьтай үнэлэгдсэн.	100
2.5.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг цахимаар ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувиар	Цахимаар ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувиар	-	100	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг "arvaikheer.uv.gov.mn", Go Uvghkhangai аппликейшн, И-Монголиа зэрэг цахим хуудсаар өргөдөл гомдлыг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны эхний 11 сарын байдлаар 360 иргэний хүсэлт ирсэн байна. Үүнээс 343 иргэний хүсэлтэд хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд хаягийн зөрүүтэй 303 хүсэлтэд татгалзаж, 40 иргэний хүсэлтэд зөвшөөрсөн байна.	95,2
Зорилго 3. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ				Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт, нийтэд ил байхаар хуульд заасан мэдээллүүдийг arvaikheer.uv.gov.mn сайтын "Ил тод" цэс, Shilen.gov.mn сайтад ил тод байршуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг ханган ажиллаж байна. Төсвийн тухай хуульд заасны дагуу тухайн жилийн төсвийн гүйцэтгэл болон ирэх оны төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцүүлэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулж хэвшсэн. Худалдан авах ажиллагааны Төсөл арга хэмжээний мэдээллийг Шилэн төсөв цэс, https://shilen.gov.mn/ , https://shilendans.gov.mn/organization/ -д, https://arvaikheer.uv.gov.mn/ , сайтуудад холбоос хийж, иргэдэд мэдээллийг ил тод хүргэж байна. Урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, захиргааны ерөнхий хуульд заасан шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог ханган саналыг цахим, болон цаасан хэлбэрээр авч бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна. 2025 онд хүнс барааны төв захын амрах өдөр тогтоох, Өвөрхангай аймгийн 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн	80
3.3.1.5. Төрийн байгууллага, албан тушаалтны үйл олон ажиллагаанд хяналтыг нийтийн журмыг хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Хэрэгжилтийн хувиар	-	70		

		үндсэн чиглэл /772/, Цэвэр агаар хөтөлбөрт тусгах санал /514/- ыг иргэнээс авч, эрэмбэлэн бодлогын баримт бичигт тусгасан.			
9.2.1.Үндэсний контентыг бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ.					
9.2.1.1.Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд зориулсан нэвтрүүлэг контентыг олон нийтэд хүргэх	Гэрээ байгуулсан хэвлэл, мэдээллийн хэрэгслийн тоогоор	7	9	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй найман хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж АТГ-аас бэлтгэсэн мэдээлэл болон авлигын эсрэг хуулийг сурталчилсан 4 удаагийн контент бэлтгэн олон нийтэд түгээн ажиллалаа.	100
9.2.1.2.Шударга ёсны чиглэлээр контент бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх	Бэлтгэсэн контентын тоогоор	-	3	Гэрээт хэвлэл мэдээллийн байгууллага UVLIVE.mn сайтаар "Авлигын эсрэг нэгдье" 1, Соёмбо телевизээр "Авлигыг тэвчье, сэргийлье" 1, UNN.mn сайтаар "Авлигад үгүй гэж хэлье" 2 удаагийн богино контентыг хийж, цахим орчинд түгээн ажиллалаа. Авлигатай тэмцэх газраас сурагчдад зориулан бэлтгэсэн "Чимээгүй үнэн" цахим номыг https://arvaikheer.uv.gov.mn/ , Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, багийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж, ерөнхий боловсролын сургуулийн номын сангуудад хэвлэн хүргүүлсэн.	100
9.3.3.Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.					
9.3.1.Насан боловсролоор дамжуулан урьдчилан соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор	-	3	Насан туршийн суралцахуйн төвөөс санаачлан хэрэгжүүлсэн "Авлигыг тэвчье, сэргийлье" аяны хүрээнд байгууллагын "Авлигагүй бүс" авлигын эсрэг самбарын мэдээллийг бүрэн шинэчлэн Авлигын эсрэг хууль, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад зориулсан "Чимээгүй үнэн" зурагт номыг бүрэн эхээр байрлуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн бэлэг, хандив авах, давхар ажил эрхлэхтэй холбоотой хязгаарлалт, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зүйл заалтуудыг байрлуулсан. "Авлигагүй ирээдүй" танхимын сургалтыг Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулж, 74 иргэн хамрагдсан. Сургалтын үеэр "Авлигыг тэвчье, сэргийлье" уриалга гарган уриалга гарган Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Засаг даргын Тамгын газрын албан хаагчид уриалгад нэгдэн 2 видео контент бэлтгэж, байгууллагын албан ёсны цахим хаягаар түгээсэн. Аяны хугацаанд ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 11е ангийн сурагчдад авлигын тухай мэдээллийг 110 утсанд хэрхэн	100

				<p>мэдээлэх талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн. Авлигагүй нийгмийг бид уриалж байна" контент бэлтгэн цахим хаягаар түгээсэн.</p>	
9.4.2. Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгох					
<p>9.4.2.2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хорт зуршлаас сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагаа, аян зохион байгуулах</p>	<p>Арга хэмжээний тоогоор</p>	2	4	<p>Ерөнхий боловсролын 6 сургуулийн хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын дунд электрон тамхины хор нөлөө, цахим орчны зохистой хэрэглээ сэдвийн хүрээнд 2 сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд 6 удаагийн сургалт, 4 удаагийн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 3200 хүүхэд хамрагдсан. Сургуулиудын өөрөө удирдах байгууллагын гишүүд 7 хоногт 3 удаа эргүүлд гарч илрүүлсэн зөрчлийн талаарх мэдээллийг нийгмийн ажилтандаа бүртгүүлж, хариу арга хэмжээ авч хэвшсэн. Тус ажлын хүрээнд 300 гаруй электрон тамхийг хурааж, Эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 8-12 дугаар ангийн 1200 гаруй хүүхдүүд тамхины хор уршиг, түүнээс татгалзах тухай сэтгэл зан төлөвийн 6 удаагийн сургалтуудыг хийж, 3500 орчим гарын авлага бэлтгэн хүргэсэн. Цахим орчны зохистой хэрэглээ, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хүмүүжлийн арга барил, хүүхдэд тавих хяналтаа сайжруулах тухай өдөрлөгүүдийг сургуулиуд дээр зохион байгуулж 1500 эцэг эх хамрагдсан. Хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлснээр хүүхэд аливаа хэлбэрийн хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх орчин нөхцөл сайжирч байна. Тус үйл ажиллагааны хүрээнд сургалт нөлөөллийн ажилд 3,9 сая төгрөг зарцуулсан.</p>	100
<p>9.4.2.3. Цахим орчинд хүүхэд гэр бүлийн зүй зохистой харилцааны талаарх мэдээллийг түгээх</p>	<p>Контент, постерийн тоогоор</p>	7	10	<p>Засаг даргын Тамгын газрын цахим хуудас, 13 багийн цахим хуудсаар дамжуулан цахим орчинд хүүхэд гэр бүлийн зүй зохистой харилцаа, эцэг эх өөрийн хүүхдийн цахим аюулгүй байдлыг хамгаалах, урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэх, цахимд мэдрэмжтэй эеж аав байа зэрэг уриалга дэвшүүлэн 19 удаагийн постер бэлтгэж ажилласан байна.</p>	100

Үнэлгээний дундаж 97,7 хувь



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА